БАТЛАВ
СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН
ПРОРЕКТОР Н.ЭРДЭНЭХҮҮ

УДИРДАМЖ

2026 оны 11. дүгээр сарын 04. Улаанбаатар хот

Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн
Оюутны Спортын XII Их Наадмыг зохион байгуулах тухай

Нэг. Наадмын зорилго:

Оюутан залуучуудын дунд нийтийн биеийн тамир спортын хөгжүүлэх, авьяаслаг залуусыг шалгаруулж, ШУТИС-ийн шигшээ багт орох оюутан тамирчдыг сонгон шалгаруулахад оршино.

Хоёр. Наадмын төрөл, зохион байгуулах хугацаа:

№	Төрлүүд	Хүний тоо			Хугацаа	Хариуцах эзэн	Явагдах байр
		Эр	Эм	Дас			
1	Үндэсний бөх	-	-	-	2026 оны 12 сарын 03-ны 10^{00} цаг	Б.Бадам-Очир	2-р байр спорт заал
2	Сагсан бөмбөг	12	12	2	2026 оны 12 сарын 04-06	Б.Ганзориг	2-р байр спорт заал
3	Волейбол	12	12	2	2026 оны 11 сарын 30-с 12 сарын 02	Л.Пүрэврагчаа Б.Дуламсүрэн	2-р байр спорт заал
4	Шатар	3	2	-	2026 оны 12 сарын 05 9^{00} цаг	Ч.Навчаа	ШУТИС Төв номын сан
5	Ширээний теннис	3	2	-	2026 оны 12 сарын 03 11^{00} цаг	М.Амаржаргал	МХТС-ийн спорт заал
6	Эрдэм шинжилгээний хурал	1			2026 оны 12 сарын 05 11^{00} цаг	Г.Ерөөлбат	ШУТИС Төв хурлын заал

Гурав. Наадмын зохион байгуулалт

Наадмыг 2026 оны 11-р сарын 30-аас 12-р сарын 06-ны хооронд зохион байгуулна. ШУТИС-ийн ХШУС-ийн Биеийн тамир, спортын тэнхим, ШУТИС-ийн Оюутны холбоо хамтран зохион байгуулна. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас төрөл тус бүрд удирдамжийн дагуу баг, тамирчид оролцоно. Спорт наадмын нэгдсэн нээлтийн ажиллагаа волейболын тэмцээний эхний өдөр, хаалтын ажиллагаа Сагсан бөмбөгийн тэмцээний сүүлийн өдөр болно. Нээлтэд сургуулийнхаа туг, жигд өмсгөлтэй оролцох ба оролцэнгүй сургуулийг тэмцээнд оролцуулахгүй.

Дөрөв. Техникийн зөвлогөөн

Техникийн зөвлөгөөн 2026 оны 11-р сарын 24-нд 18^{00} цагаас ШУТИС-ийн төв номын сангийн 2 давхарт оюутны холбооны 203 тоот өрөөнд болно. Техникийн зөвлөгөөнд зөвхөн багийн ахлагч, дасгалжуулагч нар багийн баталгаажуулсан мэдүүлэгтэй оролцоно.

Тав. Дүнгэх аргачлал, шагнал

Наадмын төрөл тус бүрд 1, 2, 3-р байр эзлүүлж өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медалиар тус тус шагнаж, нийлбэр дүнг медалийн тоо чанараар тооцон өгсөх системээр дүгнэж байр эзлүүлнэ. Нийлбэр дүнгээр тэргүүн байр эзэлсэн сургуулийг цом, өргөмжлөл, алтан медалиар шагнана.

- Нэгдүгээр байр 25 оноо
- Хоёрдугаар байр 15 оноо
- Гуравду¯аар 10 оноо
- Дөрөвдүгээр байр 5 оноо

Зургаа. Зохион байгуулагч

ШУТИС-Оюутны Холбоо, Биеийн Тамир Спортын тэнхим

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ М.БАТ-ОЧИР

ТЭРГҮҮН

УЛААНБААТАР ХОТ БАТЛАВ ОЮУТНЫ ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХОЛБОО

ШУТИС-ИЙН СПОРТ НААДМЫН ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Волейболын тэмцээний зохион байгуулагдах хугацаа

Тэмцээн 2026 оны 11 дүгээр сарын 30-аас 12 дугаар сарын 02-ний хооронд ШУТИС-ийн 2-р байрны спорт зааланд хуваарийн дагуу тус тус явагдана.

Хоёр. Тэмцээн явагдах тоглолтын систем

Багуудыг хэсгүүдэд хуваан хэсэгтээ тойргоор тоглоно. Хэсгээс 2 баг гарч хасагдах шатанд тоглоно. Хасагдах шатнаас шалгарсан багууд цаашид медалийн төлөө тоглоно. Хэсгүүдийг багууд тоглойлохгүй бөгөөд сугалаагаар шийднэ. Хасагдах шатны бүх шигшээ тоглолтууд 3 үе 25 оноогоор явагдана. Хэсгийн тоглолт явагдах онооны харьцааг техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ

Гурав. Багийн бүрэлдэхүүн

Тэмцээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас эрэгтэй, эмэгтэй тус бүр 12 тамирчны бүрэлдэхүүнтэй нэг дасгалжуулагчтай баг оролцоно. Баг тамирчид нь тухайн сургуулийн бакалаврын ангийн оюутан байна. Сургуулийн бус тамирчин тоглуулсан нь тогтоогдвол тоглолтыг хүнигдөөнд тооцох болон багийг тэмцээнээс шууд хасах арга хэмжээ авна.

Дөрөв. Багийн өмсгөл

Багууд нэр, дугаар бүхий дүрмийн дагуу тоглолтын өмсгөлтэй байна. Шаардлага хангаагүй өмсгөлтэй багийг тоглолтод оролцуулахгүй. Тоглолтын өмсгөл дээр дугаар, тоглогчийн нэр, багийн нэрийг байрлуулж болно. Багууд халааалтын хувцастай байж болно.

Тав. Бүрдүүлэх материал

- Баталгаажуулсан хичээл сонголтын хуудас
- 1% цээж зураг
- Сургуулийн тодорхойлолт

Зургаа. Тэмцээний ёс зүйн журам

- Талбайд дутуу хүнтэй баг тоглохгүй ба тоглолтын цаг болоход баг бүрдээгүй бол 10 минут хүлээж бүрдээгүй тохиолдолд эсрэг багт хожил өгнө.
- Мандатыг оюутны холбооны зохион байгуулагчдад шалгуулж шүүгчдэд шилжүүлнэ.
- Багууд нэг тоглолтын өмнө ирсэн байна.

Долоо. Шагнал

Тэмцээнд амжилттай оролцож эхний 3 байр эзэлсэн эмэгтэй, эрэгтэй баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөлөөр шагнана. Шилдэг тоглогчдыг шалгаруулж “Тусгай шагнал”-аар шагнаж урамшуулна. Багийн төрлийн дүнг нэгдсэн оноонд тооцно.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ М.БАТ-ОЧИР

УЛААНБААТАР ХОТ БАТЛАВ ОЮУТНЫ ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХОЛБОО

ТЭРГҮҮНИЙ СУРГУУЛИЙН ЭРХЛЭГДОРЖ

ШУТИС-ИЙН СПОРТ НААДМЫН САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Сагсан бөмбөгийн тэмцээний зохион байгуулагдах хугацаа

Тэмцээн 2026 оны 12 дугаар сарын 04-06-ний хооронд ШУТИС-ийн 2-р байрны спорт зааланд хуваарийн дагуу тус тус явагдана.

Хоёр. Тэмцээн явагдах тоглолтын систем

Багуудыг хэсгүүдэд хуваан хэсэгтээ тойргоор тоглоно. Хэсгээс 2 баг гарч хасагдах шатанд тоглоно. Хасагдах шатнаас шалгарсан багууд цаашид медалийн төлөө тоглоно. Хэсгүүдийг багууд толгойлохгүй бөгөөд сугалаагаар шийднэ. Тоглолтууд эмэгтэй 8 минутаар 4 үе, эрэгтэй тус бүр 10 минутаар 4 үе тус тус явагдана.

Гурав. Багийн бүрэлдэхүүн

Тэмцээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас эрэгтэй, эмэгтэй тус бүр 12 тамирчны бүрэлдэхүүнтэй нэг дасгалжуулагчтай баг оролцоно. Баг тамирчид нь тухайн сургуулийн бакалаврын ангийн оюутан байна. Сургуулийн бус тамирчин тоглуулсан нь тогтоогдвол тоглолтыг хөжигдөөнд тооцох болон багийг тэмцээнээс шууд хасах арга хэмжээ авна.

Дөрөв. Багийн өмсгөл

Багууд нэр, дугаар бүхий дүрмийн дагуу 2 ээлжийн тоглолтын өмсгөлтэй байна. Шаардлага хангаагүй өмсгөлтэй багийг тоглолтод оролцуулахгүй. Тоглолтын өмсгөл дээр дугаар, тоглогчийн нэр, багийн нэрийг байрлуулж болно. Багууд халаалтын хувцастай байх болно.

Тав. Бүрдүүлэх материал

- Баталгаажуулсан хичээл сонголтын хуудас
- 1% цээж зураг
- Сургуулийн тодорхойлолт

Зургаа. Тэмцээний ёс зүйн журам

- Талбайд дутуу хүнтэй баг тоглохгүй ба тоглолтын цаг болоход баг бүрдээгүй бол 10 минут хүлээж бүрдээгүй тохиолдолд эсрэг багт хожил өгнө.
- Тоглолт бүрд мандатыг оюутны холбооны зохион байгуулагчдад шалгуулж шүүгчдэд шилжүүлнэ.
- Багууд нэг тоглолтын өмнө ирсэн байна.

Долоо. Шагнал

Тэмцээнд амжилттай оролцож эхний 3 байр эзэлсэн эмэгтэй, эрэгтэй баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнана. Шилдэг тоглогчийг шалгаруулж “Тусгай шагнал”-аар шагнаж урамшуулна. Багийн төрлийн дүнг нэгдсэн оноонд тооцно.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ М.БАТ-ОЧИР

УЛААНБААТАР
ХОТ
БАТЛАВ
ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН
СУРГУУЛИЙН
ОЮУТНЫ ХОЛБОО
ТЭРГҮҮН АНДАГДОРЖ
АТА6451 9087087

ШУТИС-ИЙН СПОРТ НААДМЫН ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Тэмцээн явагдах журам

Монгол үндэсний бөхийн барилдааны дүрмийн дагуу зохион байгуулна.

Хоёр. Бүртгэл

2026 оны 12 сарын 03-ны 9 цагаас барилдах бөхчүүд хөлийн цэцэд бүртгүүлнэ. Бүртгүүлэхдээ оролцогчдын цахим үнэмлэх, хичээл сонголтын хуваарь авч ирж шалгуулж мандатаа авна.

Гурав. Хамрах хүрээ

ШУТИС-ийн бакалаврын анги̇н суралцагч оюутан барилдана. Нэг сургуулиас доод тал нь 2 оюутан дээшээ хэдэн ч оюутан оролцож болно.

Дөрөв. Тэмцээн зохион байгуулах хугацаа

2026 оны 12 сарын 03-нд 10^{00} цагаас ШУТИС-ийн төв спорт зааланд явагдана.

Тав. Тавигдах шаардлага

- Бөхийн иж бүрэн өмсгөлтэй байх. (Малгай, зодог, шуудга, монгол гутал)
- Зөрчил гарвал барилдаанаас хасна.
- Цолтой бол цолны үнэмлэхээ авч ирнэ.

Зургаа. Шагнал

- Түрүү, үзүүр бөх
- Шөвгийн дөрөвт үлдсэн бөх
- Дунд шөвөг

Жич: Нэг сургуулиас өндөр оноотой тамирчдын багийн нэгдсэн дүнд оруулж тооцно.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ М.БАТ-ОЧИР

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАН АГДОРЖ
АТД6451 9087087

ШУТИС-ИЙН СПОРТ НААДМЫН ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ УДИРДАМЖ

Нэг. Ширээний теннисний тэмцээний зохион байгуулагдах хугацаа

Тэмцээн 2026 оны 12 сарын 03-нд 11 цагаас МХТС-ийн спорт зааланд хуваарийн дагуу тус тус явагдана.

Хоёр. Тэмцээн явагдах тоглолтын систем

Багуудыг хэсгүүдэд хуваан хэсэгтээ тойргоор тоглоно. Хэсгээс 2 баг гарч хасагдах шатанд тоглоно. Хасагдах шатнаас шалгарсан багууд цаашид медалийн төлөө тоглоно. Хэсгүүдийг багууд тоглойлохгүй бөгөөд сугалаагаар шийднэ. Мөн эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан төрлийн аваргуудыг тодруулна. Тоглолтууд ширээний теннисний спортын дүрмээр явагдана.

Гурав. Багийн бүрэлдэхүүн

Тэмцээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас эрэгтэй-3, эмэгтэй-2 тамирчны бүрэлдэхүүнтэй баг оролцоно. Ганцаарчилсан төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр 3 хүртэл тамирчин оролцож болно. Баг тамирчид нь тухайн сургуулийн бакалаврын ангийн оюутан байна. Сургуулийн бус тамирчин тоглуулсан нь тогтоогдвол тоглолтыг хожигдсонд тооцох болон багийг тэмцээнээс шууд хасах арга хэмжээ авна.

Дөрөв. Багийн өмсгөл

Тоглолтын дүрмийн дагуу тоглолтын өмсгөлтэй байна. Шаардлага хангаагүй өмсгөлтэй багийг тоглолтод оролцуулахгүй. Багууд халааалтын хувцастай байж болно.

Тав. Бүрдүүлэх материал

- Баталгаажуулсан хичээл сонголтын хуудас
- 1% цээж зураг
- Сургуулийн тодорхойлолт

Зургаа. Тэмцээний журам

- Талбайд дутуу хүнтэй баг тоглохгүй ба тоглолтын цаг болоход баг бүрдээгүй бол 10 минут хүлээж бүрдээгүй тохиолдолд эсрэг багт хожил өгнө.
- Мандатыг оюутны холбооны зохион байгуулагчдад шалгуулж шүүгчдэд шилжүүлнэ.
- Багууд нэг тоглолтын өмнө ирсэн байх,

Долоо. Шагнал

Багийн болон ганцаарчилсан төрөлд амжилттай оролцож эхний 3 байр эзэлсэн эрэгтэй, эмэгтэй баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнана. Багийн төрлийн дүнг нэгдсэн оноонд тооцно.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ М.БАТ-ОЧИР

УЛААНБААТАР ХОТ БАТЛАВ ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХОЛБООНЫ ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАГЧ ГДОРЖ АТ46451 9087087

ШУТИС-ИЙН СПОРТ НААДМЫН ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Шатрын тэмцээний зохион байгуулагдах хугацаа

Тэмцээн 2026 оны 12 сарын 05-нд ШУТИС-ийн төв номын санд …… тоот өрөөнд 9 цагаас зохион байгуулiана.

Хоёр. Тэмцээн явагдах тоглолтын систем

Багуудыг хэсгүүдэд хуваан хэсэгтээ тойргоор тоглоно. Хэсгээс 2 баг гарч хасагдах шатанд тоглоно. Хасагдах шатнаас шалгарсан багууд цаашид медалийн төлөө тоглоно. Хэсгүүдийг багууд толгойлохгүй бөгөөд сугалаагаар шийднэ. Мөн эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан төрлийн аваргуудыг тодруулна. Тоглолтууд шатрын дүрмээр явагдана. Ганцаарчилсан тоглолтууд Швейцар системээр тоглох бөгөөд өргийн тоог оролцох хүний тооноос шалтгаалан техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ.

Гурав. Багийн бүрэлдэхүүн

Тэмцээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургуулиудаас эрэгтэй-3, эмэгтэй-2 тамирчны бүрэлдэхүүнтэй баг оролцоно. Ганцаарчилсан төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр 3 хүртэл тамирчин оролцож болно. Баг тамирчид нь тухайн сургуулийн бакалаврын ангийн оюутан байна. Сургуулийн бус тамирчин тоглуулсан нь тогтоогдвол тоглолтыг хожигдсонд тооцох болон багийг тэмцээнээс шууд хасах арга хэмжээ авна.

Дөрөв. Багийн өмсгөл

Багийн төрлийн тамирчид ижил өнгийн өмсгөлтэй байж болно.

Тав. Бүрдүүлэх материал

- Баталгаажуулсан хичээл сонголтын хуудас
- 1% цээж зураг
- Сургуулийн тодорхойлолт

Зургаа. Тэмцээний журам

- Мандатыг оюутны холбооны зохион байгуулагчдад шалгуулж шүүгчдэд шилжүүлнэ.
- Багууд нэг тоглолтын өмнө ирсэн байна.

Долоо. Шагнал

Багийн болон ганцаарчилсан төрөлд амжилттай оролцож эхний 3 байр эзэлсэн эрэгтэй, эмэгтэй баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнана. Багийн төрлийн дүнг нэгдсэн оноонд тооцно.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ М.БАТ-ОЧИР

УЛААНБААТАР
ХОТ
БАТЛАВ
ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН
ОЮУТНЫ ХОЛБООНЫ
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ
АТД6451 9087087

ШУТИС-ИЙН СПОРТ НААДМЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ “СПОРТ-ЭРҮҮЛ АМЬДРАЛ” СЭДЭВТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Дээд боловсролын салбар дахь биеийн тамир, спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинэ санал санаачилгыг дэмжих, оюутан залуучуудын идэвхийг өрнүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль бүрээс 1 оюутан оролцоно.

Гурав. Илтгэлийн үндсэн сэдэв

- Оюутан залуусын амьдралын хэв маяг ба биеийн тамир, спорт;
- Оюутан залуусын хөдөлгөөний идэвх ба эрүүл мэнд;
- Спортын шинжлэх ухаан, технологийн хөгжил;
- Спортын хөгжил ба оюутан залуусын үзүүлэх нөлөө;
- Оюутан залуусын цахим хэрэглээ ба хөдөлгөөний идэвх;
- Идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд их сургуулийн нөлөө;
- Биеийн тамир, спорт, эрүүл амьдралын хэв маягтай холбоотой бусад чөлөөт сэдэв.

Дөрөв. Илтгэл нь дараах шаардлагыг хангасан байна.

- Судалгаанд үндэслэсэн байх
- Хэрэгжүүлэхүйц шинэлэг санааг дэвшүүлсэн байх
- Бодит мэдээлэл ашиглаж, баримт материал хавсаргасан байх
- Ашигласан ном, материалын жагсаалт бичиж, ерөнхий дүгнэлт, зөвлөмжтэй байх
- Илтгэлийн сэдэв, багш, оюутны овог нэр, сургууль, салбарын нэр, холбоо барих утас, e-mail хаяг
- Илтгэлийг А4 цаасны 4-6 нүүрт багтаан, үсгийн хэмжээ 10pt, мөр хоорондын зай single space, фонт Times New Roman, цаасны бүх талаас 2,5см хэмжээтэйгээр бичнэ.
- Илтгэлийг хэвлэмэл болон файлаар бэлдэхээс гадна Power Point программ дээр арван минутад багтааж танилцуулахаар бэлтгэнэ.

Тав. Хугацаа

- Мэдүүлэг хүлээн авах: 2026 оны 11-р сарын 28-ны 18^{00} цаг хүртэл Оюутны холбоонд ирүүлнэ.
- Мэдээлэл өгөх: 2026 оны 11-р сарын 30-ны 10^{30} цагт ШУТИС-ийн Оюутны холбооны өрөөнд оролцогчид цуглаж мэдээлэл авна. Баталгаажуулсан хичээл сонголтын хуудас, нэг хувь цээж зурагтай ирж мандатаа авна.
- Зөвлөгөө авах: ШУТИС-ийн БТСТ-ээс хариусан зөвлөх багш нартай 2026 оны 11-р сарын 9-13 нд 2-13, 14 тоот өрөөнд очиж зөвлөгөө авна.

- Илтгэл хүлээн авах: **2026 оны 11-р сарын 28-ны өдөр 18^{00} цаг** хүртэл mglym@gmail.com хаягаар хүлээн авна. Имэйл-ээр ирээгүй илтгэлийг уралдаанд оролцуулахгүй, багийн оноонд тооцохгүй.
- Илтгэл явагдах хугацаа: Эрдэм шинжилгээний илтгэлийн шалгаруулалт 2026 оны 12-р сарын 05-ны 11^{00} цагт ШУТИС-ийн төв номын сангийн хурлын танхимд эхэлнэ.

Долоо. Шагнал

- Тэргүүн байр - Алтан медаль, өргөмжлөл
- Дэд байр - Мөнгөн медаль, өргөмжлөл
- Гутгаар байр - Хүрэл медаль, өргөмжлөл

Эрдэм шинжилгээний хуралд салбар сургуулиудаас оролцох илтгэгчдэд мэргэжлийн зөвлөгөө өгч, хамтран оролцох БТСТэнхимийн багш нар

д/д	Сургуулиуд	Багш	Холбоо барих дугаар
1	ХШУС	Б.Бадам-Очир	99097067
2	БАС, ГХС	Б.Ганзориг	88992020
3	МИТС	Б.Дуламсүрэн	98118107
4	МХТС	М.Амаржаргал	99097322
5	МС	М.Бат-Очир	99211212
6	ХХҮДС, НХС	Ч.Навчаа	95192512
7	ЭХИС	Л.Пүрэврагчаа	99959598
8	ГУУС	Г.Ерөөлбат	99995158

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ **М.БАТ-ОЧИР**